

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсныг
дэмжин баталгаажуулах тухай**

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк (цаашид “Банк” гэх)” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.20, 8.11.26 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Банк болон түүний холбогдох этгээд болох “Ти Ди Би Капитал” ХХК (хуучин нэр “Юнайтедбэнкинг корпорэйшн” ХХК) нарын хооронд байгуулагдсан дараах хэлцлүүдийг хүлээн зөвшөөрч, Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийг удирдлага болгон хүчин төгөлдөр байдлыг дэмжин баталгаажуулсугай.

- 1.1. Банк болон “Юнайтедбэнкинг корпорэйшн” ХХК (одоогийн нэр “Ти Ди Би Капитал” ХХК)-ийн хооронд 2021 оны 12 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан №ЗГ/СС201228047-3 дугаартай “Зээлийн нэмэлт гэрээ”, №ЗБ-СС211201010-1-3 дугаартай “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ”;
- 1.2. Банк болон “Ти Ди Би Капитал” ХХК-ийн хооронд 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан №ЗЭНГ/СС201218007-3-4 дугаартай “Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ”;
- 1.3. Банк болон “Ти Ди Би Капитал” ХХК-ийн хооронд 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан №ЗГ/СС201228047-4 дугаартай “Зээлийн нэмэлт гэрээ”, №ЗБ/СС211201010-1-4 дугаартай “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны нэмэлт гэрээ”;
- 1.4. Банк болон “Ти Ди Би Капитал” ХХК-ийн хооронд 2023 оны 3 дугаар сарын 3-ний өдөр байгуулсан №ЗЭНГ/СС201218007-3-5 дугаартай “Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ”.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА




РАНДОЛФ КОППА